

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 06 өдөр

Дугаар A/51

Баруун-Урт сум

Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг
“Комернэти” хүүхдийн вакциныг хуваарилах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/378, А/385 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын олон улсын КОВАКС хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар хүлээн авсан 126.842.198 (Нэг зуун хорин зургаан сая найман зуун дөчин хоёр мянга нэг зуун ерэн найман) төгрөгийн үнэ бүхий Пфайзер Био’Н-Тех үйлдвэрийн “Комернэти” хүүхдийн вакцин, уусгагч шингэн, эмнэлгийн хэрэгслийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хуваарилсан вакцин, уусгагч шингэн, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч, зарцуулалтад хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгахыг нягтлан бодогч (Г.Баянжаргал), Дархлаажуулалт хариуцсан эмч (Ц.Уранцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /А.Азжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

П.БОЛОРМАА





Эрүүл мэндийн газрын даргын
оны 08-р сарын 06-өдрийн
А/59-р тушаалын хавсралт

Прайзер био-тех үйлдвэрийн "Комернэти" хүүхдийн вакцин,
уусгагч шингэн, эмнэлгийн хэрэгслийн хуваарь

КОВАКС хөтөлбөр

№	Эрүүл мэндийн байгууллага	Хамрагдвал зохих 5-11 настай хүүхэд /Нийт/	ХЗХА	Олгогдох хүн тун /1 удаагийн тун/	Флаконы тоо	Уусгагч шингэн	Тариур 1мл	Тариур 2 мл	Аюулгүй хайрцаг
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Асгат СЭМТ	255	70	160	16	16	160	16	3
2	Баяндэлгэр СЭМТ	746	220	240	24	24	240	24	0
3	Дарьганга СЭМТ	415	120	260	26	26	260	26	2
4	Наран СЭМТ	246	60	70	7	7	70	7	2
5	Онгон СЭМТ	580	160	170	17	17	170	17	2
6	Мөнххаан СЭМТ	746	200	220	22	22	220	22	2
7	Түвшинширээ СЭМТ	542	150	170	17	17	170	17	2
8	Түмэнцогт СЭМТ	368	100	110	11	11	110	11	3
9	Уулбаян СЭМТ	387	110	120	12	12	120	12	1
10	Сүхбаатар СЭМТ	477	140	150	15	15	150	15	0
11	Халзан СЭМТ	246	60	70	7	7	70	7	1
12	Эрдэнэцагаан СЭМТ	1036	300	330	33	33	330	33	3
13	Энэрэл-Ачтан ӨЭМТ	2110	490	460	46	46	460	46	5
14	Энхжин-Ачтан ӨЭМТ	1850	466	380	38	38	380	38	6
	Нийт	10004	2646	2910	291	291	2910	291	32

*-Харьяалах сум өрхийн 5-11 настай хүүхдийн 25 хувийг хамруулахаар тооцов.

*-Хүүхдийг 2 тунд хамруулна. Вакцины хорогдлын индексийг 1.1-ээр тооцов.